

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/117/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Авирмэд
Утас: 70453799, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

УЛААНГОМ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 5 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.БЭРХМАА ТАНАА

2022.02.25 № МБА-2022/117/17-СТА-ТМЗ
танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

0200200231

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	6
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>108,184,387.86</u>	<u>103,146,057.86</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	108,184,387.86	103,146,057.86
351	Түүхий эд материал	8,179,722.86	8,377,322.86
35110	Тусгай зориулалттай материал	7,897,022.86	7,897,022.86
35130	Эм боох материал	282,700.00	480,300.00
354	Хангамжийн материал	100,004,665.00	94,768,735.00
35420	Аж ахуйн материал	14,863,800.00	16,196,200.00
35440	Түлш, шатах тослох материал	7,350,700.00	847,000.00
35460	Хүнсний материал	1,222,420.00	1,157,790.00
35470	Бусад хангамжийн материал	76,567,745.00	76,567,745.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,031,673,693.69</u>	<u>3,849,537,677.40</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,031,673,693.69	3,849,537,677.40
392	Биет хөрөнгө	3,585,579,915.97	3,404,110,566.40
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,738,231,250.00	3,738,231,250.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-335,617,144.48	-478,426,725.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	302,355,286.53	219,259,321.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-204,806,025.18	-145,759,912.44
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	124,052,791.90	109,180,555.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-70,118,203.80	-71,798,914.54
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,208,500.00	2,208,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,208,500.00	-2,208,500.00
39217	Ном	31,481,961.00	33,424,991.88
393	Биет бус хөрөнгө	446,093,777.72	445,427,111.00
39301	Программ хангамж	3,285,000.00	3,285,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,007,222.28	-2,673,889.00
39303	Бусад биет бус хөрөнгө	444,816,000.00	444,816,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,139,858,081.55</u>	<u>3,952,683,735.26</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,139,858,081.55</u>	<u>3,952,683,735.26</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,139,858,081.55	3,952,683,735.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	955,381,964.11	955,381,964.11
51101	Өмч: - төрийн	955,381,964.11	955,381,964.11
512	Хуримтлагдсан үр дүн	2,974,898,580.98	2,787,724,234.69
51210	Өмнөх үеийн үр дүн	2,974,898,580.98	2,974,898,580.98
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-187,174,346.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	209,577,536.46	209,577,536.46
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,139,858,081.55</u>	<u>3,952,683,735.26</u>

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,185,554,766.86	1,102,799,878.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,182,746,266.86	1,097,924,453.88
120	Нийтлэг татварын бус орлого	95,199,666.86	1,890,430.88
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,710,030.88
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	1,710,030.88
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,087,546,600.00	1,096,034,023.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	948,688,800.00	933,742,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,808,500.00	4,875,425.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,808,500.00	4,875,425.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,808,500.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,650,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	225,425.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,275,280,615.92	1,289,974,225.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,275,280,615.92	1,289,974,225.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,224,889,208.92	1,257,064,024.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	767,398,656.00	752,831,820.00
210101	Үндсэн цалин	541,083,699.00	539,185,345.00
210102	Нэмэгдэл	161,487,090.00	162,478,700.00
210104	Урамшуулал	64,827,867.00	51,167,775.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,998,486.00	99,088,325.00
210201	Тэтгэврийн даатгал	67,241,186.00	69,422,125.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,689,100.00	7,416,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,151,500.00	5,933,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,537,700.00	1,483,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,379,000.00	14,833,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	130,427,176.00	158,476,023.00
210301	Гэрэл, цахилгаан	13,550,381.00	15,082,897.00
210302	Түлш, халаалт	112,119,295.00	141,446,126.00
210303	Цэвэр, бохир ус	4,757,500.00	1,947,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,111,180.00	10,257,629.00
210401	Бичиг хэрэг	1,174,000.00	1,216,625.00
210402	Тээвэр, шатахуун	733,756.00	563,380.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	956,074.00	828,324.00
210404	Ном, хэвлэл	21,350.00	33,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,276,900.00	4,271,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	949,100.00	3,345,000.00
2105	Нормативт зардал	23,886,880.00	34,338,330.00

Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	334,250.00	172,700.00
210502	Хоол, хүнс	22,210,630.00	33,525,630.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,342,000.00	640,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,290,300.00	10,319,400.00
210604	Урсгал засвар	9,290,300.00	10,319,400.00
2107	Томилолт, зочны зардал	746,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	746,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,557,555.00	3,144,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,200,000.00	1,040,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	650,000.00	1,954,100.00
210807	Газрын төлбөр	131,555.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	186,472,975.92	188,608,097.17
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,736,800.00	2,769,150.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	183,736,175.92	185,838,947.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,391,407.00	32,910,201.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,992,800.00	24,893,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,992,800.00	22,307,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	2,586,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	302,524.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	302,524.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,096,083.00	8,016,801.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,096,083.00	8,016,801.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-89,725,849.06	-187,174,346.29
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-89,725,849.06	-187,174,346.29

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,090,355,100.00	1,100,909,448.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,087,546,600.00	1,096,034,023.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,087,546,600.00	1,096,034,023.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	948,688,800.00	933,742,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,808,500.00	4,875,425.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,808,500.00	4,875,425.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,808,500.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,650,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	225,425.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,090,355,100.00	1,100,909,448.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,090,355,100.00	1,100,909,448.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,039,963,693.00	1,067,999,247.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	767,398,656.00	751,921,057.00
210101	Үндсэн цалин	541,083,699.00	538,274,582.00
210102	Нэмэгдэл	161,487,090.00	162,478,700.00
210104	Урамшуулал	64,827,867.00	51,167,775.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,998,486.00	99,999,088.00
210201	Тэтгэврийн даатгал	67,241,186.00	70,332,888.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,689,100.00	7,416,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,151,500.00	5,933,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,537,700.00	1,483,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,379,000.00	14,833,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	129,264,976.00	151,972,323.00
210301	Гэрэл, цахилгаан	13,550,381.00	15,082,897.00
210302	Түлш, халаалт	110,957,095.00	134,942,426.00
210303	Цэвэр, бохир ус	4,757,500.00	1,947,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,668,480.00	10,236,429.00
210401	Бичиг хэрэг	539,300.00	1,040,425.00
210402	Тээвэр, шатахуун	733,756.00	563,380.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	956,074.00	828,324.00
210404	Ном, хэвлэл	266,350.00	266,300.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,371,900.00	3,650,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	801,100.00	3,888,000.00
2105	Нормативт зардал	23,884,240.00	35,821,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	370,550.00	370,300.00
210502	Хоол, хүнс	22,021,690.00	33,461,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,492,000.00	1,990,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,290,300.00	12,079,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,759,900.00
210604	Урсгал засвар	9,290,300.00	10,319,400.00
2107	Томилолт, зочны зардал	746,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	746,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,557,555.00	3,144,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,200,000.00	1,040,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	650,000.00	1,954,100.00
210807	Газрын төлбөр	131,555.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,155,000.00	2,825,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,155,000.00	2,825,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,391,407.00	32,910,201.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,992,800.00	24,893,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,992,800.00	22,307,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	2,586,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	302,524.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	302,524.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,096,083.00	8,016,801.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,096,083.00	8,016,801.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	510,565,964.11	00.00	2,914,471,852.49	3,425,037,816.60
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	510,565,964.11	00.00	2,914,471,852.49	3,425,037,816.60
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	444,816,000.00	00.00	-17,817,703.39	426,998,296.61
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	955,381,964.11	209,577,536.46	2,974,898,580.98	4,139,858,081.55
2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	955,381,964.11	209,577,536.46	2,974,898,580.98	4,139,858,081.55
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	955,381,964.11	209,577,536.46	2,974,898,580.98	4,139,858,081.55
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-187,174,346.29	-187,174,346.29
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	955,381,964.11	209,577,536.46	2,787,724,234.69	3,952,683,735.26

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,097,828,000.00	1,088,017,222.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,097,828,000.00	1,088,017,222.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,074,209,100.00	1,064,398,822.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	752,045,600.00	751,921,057.00
210101	Үндсэн цалин	538,300,700.00	538,274,582.00
210102	Нэмэгдэл	162,478,700.00	162,478,700.00
210104	Урамшуулал	51,266,200.00	51,167,775.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101,526,000.00	99,999,088.00
210201	Тэтгэврийн даатгал	71,444,300.00	70,332,888.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,520,400.00	7,416,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,016,300.00	5,933,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,504,100.00	1,483,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,040,900.00	14,833,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	153,765,700.00	151,972,323.00
210301	Гэрэл, цахилгаан	14,650,000.00	15,082,897.00
210302	Түлш, халаалт	134,942,500.00	134,942,426.00
210303	Цэвэр, бохир ус	4,173,200.00	1,947,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,210,000.00	9,205,904.00
210401	Бичиг хэрэг	494,900.00	494,900.00
210402	Тээвэр, шатахуун	563,500.00	563,380.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	831,900.00	828,324.00
210404	Ном, хэвлэл	266,600.00	266,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,300,000.00	3,300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,753,100.00	3,753,000.00
2105	Нормативт зардал	40,484,500.00	35,821,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	371,000.00	370,300.00
210502	Хоол, хүнс	38,123,200.00	33,461,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,990,300.00	1,990,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,320,000.00	10,319,400.00
210604	Урсгал засвар	10,320,000.00	10,319,400.00
2107	Томилолт, зочны зардал	755,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	755,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,906,600.00	2,964,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,100,000.00	1,040,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	876,000.00	00.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,780,600.00	1,774,100.00
210807	Газрын төлбөр	150,000.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2195700.00	2195350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,195,700.00	2,195,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23618900.00	23618400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,618,900.00	23,618,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,307,400.00	22,307,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,311,500.00	1,311,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,097,828,000.00	1,088,017,222.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	933,742,300.00	925,725,499.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	933,742,300.00	925,725,499.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	164,085,700.00	162,291,723.00
132001	Орон нутгийн төсвөөс	164,085,700.00	162,291,723.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	65.00	65.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	48.00	48.00
620003	Үйлчлэх ажилтан	16.00	16.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	321.00	419.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	320.00	418.00
630001	Төрийн өмчит ЕБС	320.00	418.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	01.00	01.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	01.00	01.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	65.00	65.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	41.00	41.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	24.00	24.00

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,875,425.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,875,425.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,600,425.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,030,525.00
210401	Бичиг хэрэг	545,525.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	350,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	135,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,759,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,759,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	180,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	630000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	630,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1275000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,275,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,275,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4875425.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,875,425.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,650,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	225,425.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3 . Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь нь бүх нийтийн ерөнхий боловсролыг суралцагчдад эзэмшүүлэх зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв

толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 9.1 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,289.9 сая төгрөгийн 1 хувь буюу 12.9 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 10.3 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 187,174.3 мянган төгрөгөөр буюу 4,5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	108,184.3	103,146.1	-5,038.2
Үндсэн хөрөнгө	4,031,673.7	3,849,537.6	-182,136.1
Нийт хөрөнгө	4,139,858.0	3,952,683.7	-187,174.3
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,139,858.0	3,952,683.7	-187,174.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,139,858.0	3,952,683.7	-187,174.3

Бараа материалын дансны үлдэгдэл 103,146.1 мянган төгрөг болж 5,038.2 мянган төгрөгөөр буурсан нь халаалтын зардлыг аж ахуйн нэгж рүү шилжүүлж түлш шатах тослох материалын нөөц буурснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,849,537.6 мянган төгрөг болж 182,136.1 мянган төгрөгөөр буурсан нь машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил акталснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,952,683.7 мянган төгрөг болж 187,171.3 мянган төгрөгөөр буурсан нь нь машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил акталсан, хөрөнгийн хуримтлагдсан элэгдлээс шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 82,754.8 мянган төгрөгөөр буюу 6.9 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 14,693.6 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,451,125.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,451,125.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 353,297.3 мянган төгрөгөөр бууруулж 1,097,828.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалингийн сан, хоол хүнс, үдийн цай хөтөлбөр, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлуудын санхүүжилт буурч ирсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,097,828.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 933,742.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 164,085.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 933,742.3 мянга, орон нутгийн төсвөөс 162,291.7 мянга, нийт 1,096,034.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,088,017.2 мянган төгрөгийг зарцуулж, 8,016.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,088,017.2 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байгаа нь зардлыг 8,016.8 мянган төгрөгөөр хэмнэж орон нутгийн төсвөөс 1,794.0 мянган төгрөгийн санхүүжилт дутуу ирсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 4,650.0 мянга, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 225.4 мянга нийт 4,875.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бичиг хэргийн зардалд 545.5 мянга, хог хаягдлын зайлуулах хортон мэрэгчдийн устгал ариутгалын зардалд 350.0 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлсийн зардалд 135.0 мянга, багаж техник хэрэгслийн зардалд 1,759.9 мянга, мэдээллийн технологийн зардалд 180.0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 1,275.0 мянга, нийт 4,875.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх аудитаар илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахгаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 146, хугацаа хоцроосон 3, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,706.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3,706.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

4.2 Төлбөрийн акт

Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь нүүрс худалдан авах тендер шалгаруулахдаа хамгийн бага үнэтэй буюу 1 тонн нүүрсийг 48.0 мянган төгрөгөөр нийлүүлэх үнийн санал ирүүлсэн компанийг шалгаруулсан ч 1 тонн нүүрсийг 58.0 мянган төгрөгөөр худалдан авах гэрээ байгуулж 370.6 тонн нүүрс худалдан авч төрд 3,706.0 мянган төгрөгийн хохирол учруулсан зөрчилд төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган.төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль	1	3,706.0			1	3,706.0				
НИЙТ		1	3,706.0			1	3,706.0				

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР  /Б.АВИРМЭД/

2022 оны 02 сарын 22-ны өдөр